

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ШИЛЖИЛТИЙН АЗИЙН ЗАГВАР: МОНГОЛД ЗОРИУЛЖ ХАРЬЦУУЛСАН СУРГАМЖ

**Проф.Кеун Ли.БНСУ-ын Сеулын
их сургуулийн эдийн засгийн салбар**

Ази, Европын олон орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт олон янзын арга замаар шилжиж байгаа тул эдийн засгийн дүн шинжилгээ хийвэл зохих өдий төдий асуудал, ер бусын тохиолдол гарч ирж байна.Хятад болон Зүүн Европын орнууд дахь шинэчлэлтийн дараах байдал эрс ялгаатай байгаа нь анхаарч судлууштай асуудлын нэг мөн.Хувьчлал ямар хурдацтай байсан, хувьчлал, шинэчлэлтийн бусад алхамын хооронд хэр зэрэг ялгаа зөрөө байгаа гэх зэрэг хэд хэдэн үндэслэлээр Монгол улс социализмын дараах үеийн шинэчлэлтийн гайхамшигтай жишээг бас үзүүлж байна.

Азийн орнууд дахь эдийн засгийн шинэчлэлт харьцангуй илүү үр дүнтэй байгаа учраас "Шинэчлэлт, шилжилтийн Азийн загвар" хэмээх нэгдсэн дүгнэлт гарсан юм.1-рт, Шилжилтийг (буюу эдийн засгийн шинэчлэлт) урт хугацааг туулахгүйгээр хэрэгжүүлж болно.2-рт, шинээр зах зээл бий болгох, хангамжийн бүтцийг дахин бүрдүүлэх, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд заавал хувьчлал хийх гэх шаардлагагүй.3-рт, төсвийн хүндрэл эдийн засгийн хүрээнд гэхээсээ илүү улс төр-эдийн засгийн хүрээнд нөлөөлдөг гэсэн онолыг агуулдаг хувьчлалгүйгээр төсөвт хэсэгчилсэн хяналт тавьж болно.4-рт, улс орны хувьд эдийн засгийн асуудал давамгайл байр суурь эзэлснээр төрийн өмчийн хамгаалалт сайжирч, ялангуяа үйлдвэр, аж ахуйн газрууд, татварын шинэчлэлд нэн ашиг тустай байна.Үүний зэрэгцээ зах зээлийн эмх замбараагүй байдлыг арилгах, дотоодын хяналтанд шаардагдах зардал төсвийг хэмнэх боломжтой болдог.

Ази, Европын хоорондоо тэс ондоо шилжилтийн үйл явц яаж өрнөсөнд эдийн засгийн дүн шинжилгээ хийхдээ цочир эмчилгээний аргаар дэс дараатай авч хэрэгжүүлэх стратеги бодлого болон анхдагч өөр өөр нөхцөл байдал гэсэн хоёр үзэл бодлын алиныг нь сонгох вэ гэдэг дээр анхаарлаа хандуулах ёстой.

Шилжилтийн талаархи маргаанд анхаарал татах бас нэг асуудал бол улсын үйлдвэрийн газруудыг хувьчлах нь өсөлт хөгжлийн шинэ эх үүсвэр, эдийн засгийг зах зээлд шилжүүлэх бас нэг арга гэсэн ойлголт юм.Энд шинэчлэлтийн үеийн гурван асуудлыг авч үзье.Үүнд: 1-рт, цочир эмчилгээний аргыг дэс дараатай авч хэрэгжүүлэх, 2-рт, нэгдүгээрхтэй

холбоотойгоор анхдагч нөхцөл ижил байвал шинэчлэлтийн ямар стратеги баримтлах вэ гэсэн асуудал (өөрөөр хэлбэл эрс шийдэмгий алхам хийх үү аль эсвэл аажмаар шилжих үү гэсэн), 3-рт, шинээр зах зээлд хөл тавьж байгаа үйлдвэр аж ахуйн газрууд, хуучин улсын мэдэлд байсан аж ахуйн газруудыг хувьчлах хоёрын ялгаа зэрэг юм.

Нөгөө талаар шилжилтийн үедээ яваа Азийн орнууд, түүний дотор Хятад, Монгол, Вьетнам нь бүгд хөгжиж буй орнууд учраас шилжилтийн нөгөө утга нь хөгжил дэвшил гэж хэлж болохоор байна."Шилжилт" гэдгийг эдийн засгийн арга хэмжээний үр дүн нийгмийн хүчин зүйлүүдээс хамаарах нь багасч, эдийн засгийн үр дүнг үнэлэх зах зээлийн үнэлэмж дээшлэх явдал буюу "зах зээлд шилжих үйл явц" гэж ойлгож болно. Харин хөгжил гэдгийг эдийн засгийн дундаж бүтээмж тасралтгүй өсөх явдал гэж ойлгоно. Дундаж гэсэн ойлголтод нэг хүнд ногдох хувь, ажлын нэгжид ногдох өмч, нэг хүнд ногдох үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн ч байж болох юм.Эдийн засгийн гол гол салбаруудын хоорондох уялдаа холбоо нь хөгжлийн салшгүй нэг хэсэг болдог. Эдийн засгийн хөгжлийн түвшин, хуваагдашгүй нэгдмэл байдал, анхны алхмаа хийх үед төрдөг болгоомжлол эд бүгд нь хөгжил дэвшил явагдаж эхэлсний шинж тэмдэг юм.Ингэхлээр гадаадын бараа тавгаарт үүд хаалгаа нээх зэрэг зах зээлд шилжих үйл явц нь үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээг тасралтгүй нэмэгдүүлдэг байна.Үр ашигтай чөлөөт худалдаа, үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын төлөө хувь хүн хариуцлага хүлээдэг болсны үр дүнд Азийн шилжилтийн загвар гарч ирсэн гэж англи-саксоны эдийн засагчид тайлбарлажээ.Харин "Зүүн Азийн гайхамшиг" гэдэг бүтээлд үүнийг арай өөр талаас нь авч үзсэн байна.Үйлдвэр хөгжүүлэх бодлого, хөгжил дэвшилд төрийн үүрэг их байдгийг тэд үгүйсгээгүй бөгөөд улс төрийн хувьд дундыг баримтлан, эдийн засгийн хувьд зөв зохистой оролцож чадаж байгаа тийм төр л зөвхөн энэ үүргээ биелүүлж чадна гэж бичжээ.¹

Бид энэ илтгэлдээ: Хятад, Монгол, Вьетнамд төрийн үүрэг ямархуу байгааг хөрш зэргэлдээх капиталист орнуудтай нь харьцуулж үзэв.Зүүн Азийн орнууд социалист элемент бүхий капиталист замаар хөгжсөн болохоор ийм харьцуулалт бас ч хэрэгтэй.Эдгээр орны банкууд улсын мэдэлд буюу улсын хяналтан доор үйл ажиллагаагаа явуулдаг, улсын мэдлийн үйлдвэр аж ахуйн газрын тоо харьцангуй олон (ялангуяа Тайваньд), хувийн аж ахуйтны хэрэгт улс хөндлөнгөөс оролцох нь их байдаг.Тэгэхлээр Монгол, Вьетнам, Хятад, Солонгос, Япон, Тайванийг цэвэр капиталист зах зээлийн орнууд болон төвлөрсөн төлөвлөгөөт, социалист эдийн засагтай орнуудын хүрээнд багтдаг гэж хэлж болохоор байна.Төлөвлөгөөт болон зах зээлийн эдийн засаг Зүүн Азийн капиталист системд зэрэгцэн оршиж байгаа нь шилжилтийн үеийн тун ч ашигтай загвар болж болох юм гэдэгтэй Ази болон Зүүн европын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байсан орны эдийн засагчид санал нэгтэй байна.Төрийн үүргээс гадна бидний харьцуулсан дүн шинжилгээний бусад талыг, тухайлбал хөгжлийн бусад хэмжүүр болдог

хөрөнгийн хуримтлал (иргэдийн хадгаламж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаадынхнаас мөнгө зээлэх гэх мэт) экспортын үүргийг энд бас тэмдэглэх ёстой.

Дүгнэн хэлэхэд, бидний энэхүү дүн шинжилгээ нь Зүүн Азийн улс орнуудад өрнөсөн шилжилт, хөгжил дэвшилтэй холбоотой “зах зээлд хожуу шилжих”, “хожуу аж үйлдвэржих” асуудалд гол анхаарлаа хандууллаа. Энэ хоёр асуудал нь хоорондоо хүйн холбоотой болохоор саланги тусад нь авч үзэх боломжгүй багц асуудал юм. Үүнээс үзэхэд Солонгос, Тайвань, Япон улс “хожуу аж үйлдвэржих чиглэлээр, харин Хятад, Монгол, Вьетнам улс “зах зээлд хожуу шилжих” замаар явсан нь харагдаж байна.

Судалгааны дүнгээс үзэхэд эдийн засгийн хөгжил, шилжилтийн Хятад, Японы гэх мэт том орны, Солонгос, Тайвань, Монгол, Вьетнам зэрэг жижиг орны загвар байж болох юм. Энэ тохиолдолд эдийн засгийн нөхцөл байдлын ялгаа байж болох боловч хоёр бүлэг орны хооронд төсөөтэй зүйл олон ажиглагддаг болохоор улс орны хэмжээ том жижиг байх нь нэг их чухал биш ажээ. Зах зээлд хожуу шилжих, хожуу аж үйлдвэржих үйл явцыг нэгтгэн шинжлэж үзээд бид шилжилтийн үед яваа бага шиг орон болох Монголын хөгжлийн стратегид зөвлөмж, сургамж болохоор зүйлүүд байгааг олж харлаа.

2.ЗҮҮН АЗИЙН ГАЙХАМШИГ ХЭМЭЭХ ЗАГВАРЫН ЧАДАМЖ, ЭРСДЭЛ

Солонгос, Тайвань, Япон гэсэн Зүүн Азийн 3 орны хөгжилд гурван чухал хүчин зүйл байна. 1-рт, эдгээр оронд төрийн оролцоо идэвхтэй байгаа нь зөвхөн удирдагчдын санаа бодлоос хамаарч байгаа явдал биш, харин тэд банк болон зээл олгох чадамжтай санг эзэмшиж, эдийн засгийн бодитой эрх мэдэлтэй байгаад гол нь байгаа юм. Эдгээр оронд том бизнесийн ажил хэрэгт төрийн зүгээс өөрийн үзэмжээр санхүүгийн хяналт тавих, жижиг орнуудад байх боломжгүй чанарын янз бүрийн хяналтын механизм үйлчилдэг байна. 2-рт, тэдний бизнес нь буцах эзэнтэй, зах зээлийн сахилгыг чанд баримталсан (ялангуяа Тайвань, Солонгосын гадаад зах зээл рүү чиглэсэн бизнесийн хувьд) сахилгын давхар механизмд захирагддаг бөгөөд зах зээлийн хуулинд зохицсон сахилга хариуцлагын сүлжээ нь мэдээлэл сайтай улсын агентлагууд, бизнесийн хүрээнийхний хооронд тогтсон удаан хугацааны харилцаан дээр үндэслэсэн байдаг. 3-рт, төрийн оролцоо хэсэгчилсэн байдалтай, жижиг бизнесийнхэн рүү чиглэсэн хувийн секторт бараг байдаггүй, зөвхөн стратегийн ач холбогдолтой, хувийн секторынхныг бараг оруулдаггүй чиглэсэн тодорхой хэдэн салбарт үйлчилдэг ажээ. Дээр дурьдсан гурван хүчин зүйлээс гадна шилжилт амжилттай явагдаж байгаа Зүүн Азийн эдгээр оронд өсөлт хөгжилтийн чиг баримтлагч улс

төрийн хатуу удирдагч, үндэсний нэг санаа, эв нэгдэл нөлөөтэйг үгүйсгэх аргагүй.

Энэ систем сайн ажиллахад зарим нэгэн хүчин зүйл нөлөөлдөгийг дээрх 3 орны жишээ харуулж байна. Хэдийгээр эдгээр орон хөгжлийн янз бүрийн түвшинд хүрсэн боловч тэдгээр нь Күнзийн хатуу номлолыг өвлөн авсан түүхэн нийтлэг сэжигээр холбодог. Дангаар ноёлох дэглэмтэй эдгээр 3 орон нийгмийн зүгээс үзүүлж болох партизанчилсан шахалт дарамтыг дарах, эдийн засгийн өсөлт нь олон түмний тусын тулд хийгдэж байгаа юм гэдэгт ард түмнээ итгүүлэх, үйлдвэржүүлэх сайн төлөвлөгөөтэйгээс гадна хувийн хэвшлийнхний дэвшилтэт санаа бодлыг дэмжих, улс төрийн тогтвортой байдал удаан үргэлжлэх нь хувийн хэвшлийнхний сонирхолд нийцнэ гэдэгт итгүүлж чадах чадвартай болжээ. Энэ загварыг сүүлийн үед сайн мэдээлэл бүхий түшмэлүүдээр толгойлуулсан, Күнз болон үндэсний үзлийг номлодог, гадаад руу чиглэсэн, хамгаалалт сайтай капиталист үндэсний байшин гэж нэрлэх болжээ.

Төрийн оролцооны түвшин ямархуу байдгийг төсөөлөхөд хялбар болгохын тулд зүүн гар талд нь хамгийн их, баруун талд нь хамгийн бага оролцоо гэсэн хоёр туйлыг босгоё. Шинэчлэлт эхлэхээс өмнө дээр дурдсан улс орнууд голын шугамнаас ихээхэн зүүн талд байсан. Голчийг нь олж, донжийг нь тааруулахад ямар хэцүү байдгийг Японы жишээ харуулж өгчээ.²

Зах зээлийн байгууллагын зарчмын үйл ажиллагаа нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа хүмүүсийг нэрлэн, тэдний авдаг цалин хөлс нь шагнал урамшуулал, торгууль шийтгэлдээ хир тохирч байгааг зохицуулах явдал юм. Төвлөрсөн төлөвлөгөөт социалист эдийн засагтай Хятад, Монгол, Вьетнамд энэ холбоо алдагдсанаас түлхэц, урамшуулал үгүй болсон байв. Харин дээр дурдсан капиталист 3 оронд төрийн оролцоо зах зээлийн хэвийн ажиллагаанд саад болдоггүй, үр дүнтэй байсан болохоор үйлдвэрлэгчид нөөц баялгийг үргүй зарцуулах явдал гардаггүй байлаа. Түүнээс гадна эдгээр 3 орны зах зээлийн сүлжээний байгууллагуудын ажиллагаа нь хөгжлийн чиг баримталдаг улс төрийн хатуухан удирдагч, зах зээлийн шалгуур заавал байхыг шаардаж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Бизнесийн хүнд сурталтнуудын зүгээс далд хуйвалдааны шинжтэй, хууль бус, үр ашиггүй үйл ажиллагаа явуулахаас хамгаалах хэрэгтэй байв.³

Бизнесийнхэн болон албаны түшмэдүүдийн хооронд далд хуйвалдаан байж болох талтайг шалган нягтлах нь эдгээр 3 орны бизнес нь гадаад орчин руу чиглэсэн, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд оролцдог болохоор бүр ч их ач холбогдолтой юм. Банкнаас (гадаад дотоодын аль алианаас нь) зээл авах шалгуур үзүүлэлт нь дэлхийн зах зээл дээр хир амжилттай өрсөлдөж чадаж байгаагаар тодорхойлогдоно. Эдгээр орны туршлагаас харахад, гадаад зах зээл рүү

чиглэсэн үйл ажиллагаа нь дотоод эдийн засгийн бодлогод зарим талаар сөрөг нөлөө үзүүлж, хөгжлийг сааруулдаг талтай. Экспортын чиглэлтэй компаниуд, улс төрийн удирдагчдаас эдийн засаг-улс төрийн хувьд үр ашигтай бодлого явуулахыг гадаад ертөнцөд тодорхойлогч нөлөөтэй дэлхийн зах зээлийн үнэ шаардаж байна.

Нөгөө талаас Солонгост өнөөдөр үргэлжилж байгаа эдийн засгийн хямралын олон шалтгааны нэг нь хугацаа дуусчихаад байхад хүртэл түрээс авахыг 1997 оны эцсээс одоо хүртэл зөвшөөрч байсан явдал юм. Эдийн засгийн өндөр өсөлтийн үед экспортын гүйцэтгэл нь гадаад солилцоо болон банкны зээлээр хөрөнгө байрлуулах цорын ганц цэвэр шалгуур болж байлаа. Гэтэл экспорт болон зээлийн хоорондын холбоо аажмаар алга болж зээл борлуулах өөр механизм байхгүй болсноор зөвхөн банкны чөлөөт систем, хөрөнгийн зах зээл хоёр л үлдсэн юм. Ийм нөхцөлд цэвэр эдийн засгийн гүйцэтгэлээр (экспорт) биш, лоббидох зэрэг улс төрийн аргаар түрээс авах хандлага давамгайлахад хүргэж засгийн газрын хүнд сурталтнууд тодорхой, шударга шалгуургүйгээр мөнгө зээлийн болон хөрөнгийн зах зээлд хөндлөнгөөс оролцсоор байна.

1. Хөрөнгийн хуримтлал гадаад хадгаламжийн үүрэг

Удаан хугацааны эдийн засгийн өсөлтөд хөрөнгийн хуримтлал хамгийн чухал асуудал байдаг. Ялангуяа дотоод хадгаламж багатай ядуу оронд онцгой чухал ач холбогдолтой юм. Өмнөд Солонгос 1960-аад оноос өсөлтийн замд ороход ийм байлаа.

Монголын хувьд хөрөнгө оруулалт их биш, ердөө 20 орчим хувь байгаа нь хамгийн бага юм. Харин Монголыг 1965 оны Солонгостой харьцуулбал хоёр орны хөрөнгө оруулалтын хэмжээ ойролцоо, Японых 16 хувь байна. (Хадгаламжийн цоорхой Монголд 3 орчим хувь байгаа нь 1965 оны Солонгосынхоос их доогуур байна. Орлогын хэмжээ бага байгааг харгалзан үзвэл Монголд дотоодын зах зээл, хүний нөөцийн хэмжээ бага учраас гадаадын шууд хөрөнгө оруулалт хийхэд бэрхшээлтэй байдгаас үүдэн гадаадаас зээл тусламж авах нь их байна. Энэ утгаараа Монгол нь Солонгос мэтийн бага өсөлттэй орнуудын бүлэгт хамаарах болж байна.

2. Экспортын үүрэг

Азийн эдийн засгийн стратегийн маргаанд Зүүн Азийн гадагш чиглэсэн экспортын баримжаатай өсөлт, Латин Америкийн дотогш чиглэсэн импорт тэргүүлсэн өсөлтийн хооронд их ялгаа харагддаг юм. Латин Америк 1980-иад оноос экспортын баримжаатай өсөлт рүү эргэж, Азийн эдийн засаг сайжирсныг үзвэл экспорт тэргүүлсэн өсөлт илүү гэдэг нь харагдана. Ямар учраас гадагш чиглэсэн өсөлтийн баримжаа хөгжлийн илүү үр дүнтэй стратеги байдаг вэ гэж дахин

асууя.Эдийн засгийн өсөлтийг хангахын тулд зах зээлд шаардлагатай техник төхөөрөмж, хөрөнгө авахаас өөр ямар ашиг гадаад худалдаа өгдөг вэ? Дэлхийн зах зээлд оролцох нь эдийн засагт онцгой нөхцөл шаарддаг бөгөөд засгийн газар ямар бодлого баримтлахаа сонгох болдог нь мэдээж. Гэвч энэхүү аргагүй байдал нь тэдгээрийн ашигтай шууд хамааралтай байх албагүй.Экспортын баримжаа нь дотоод зах зээлээс хамгаалалттай үйлдвэрлэгчдэд ямагт ашигтай байх нөхцөл бүрдүүлэх боломжгүй байдаг зах зээлийн хуулийг бий болгоно.Ингэснээр дотоод зах зээлийн бодлогод аргагүй байдлын сүлжээ үүсгэж өсөлтөд халгаатай арга хэмжээ авахаас сэргийлдэг юм.Илэрхий тодорхой болсон зах зээлийн үнэ нь эдийн засгийн болон улс төрийн хувьд үр ашигтай ажиллахыг экспортын баримжаатай компаниуд болон улс төрийн удирдлагад шаарддаг.Өөрөөр хэлбэл, тухайн орны дотоодод эдийн засаг, улс төрийн өрсөлдөөн хомс байсан ч дэлхийн зах зээл дэх өрсөлдөөнөөр нөхөгдөнө гэсэн үг юм.Ийм л шалтгаанаар Солонгосын чаеболууд болон Тайваний улсын үйлдвэрүүд дотооддоо өрсөлдөөнөөс хамгаалалттай боловч үр ашигтай ажиллаж, өрсөлдөх чадвартай болсон юм.Гэтэл дотогшоо баримжаатай эдийн засагт ийм хууль үйлчилдэггүй бөгөөд үүний улмаас аль болохоор их нөөц ашиглаж, түрээс хайх үйл ажиллагаа голлодог.⁴

Монгол Улс шинэтгэлийн дараа дэлхийн худалдаанаас хамгийн их хамааралтай орнуудын нэг гэнэтхэн боллоо.Дотоодын нийт бүтээгдэхүүнд худалдааны эзлэх хувь 1980 онд 58 хувь, 1995 онд 104,6 хувь хүртэл үсрэв.Хэрэв дотоодын нийт бүтээгдэхүүнд экспортын эзлэх хувь 60 хувиас дээш болвол Монгол экспортын баримжаатай эдийн засагтай орон болно.Гадагш чиглэсэн, экспортын баримжаатай өсөлтийн стратеги нь Монголын хувьд жинхэнэ сонголт болж байна.Учир нь Монгол зах зээлийн замаар хөгжих үү, дотоодын жижиг зах зээлээс хамааралтай түгжигдмэл эдийн засагтай байх уу гэдгийг сонгох бэрхшээл тулгарч байна.Импортыг чөлөөтэй болгоогүй цагт дотоод зах зээл монопол эрхтэй байх болно.

3.Аж үйлдвэрийн болон хүн ам зүйн бүтэц

Монголд гуравдагч салбарын эзлэх хувь өндөр (бараг 50 хувь) хоёрдогч салбарынх 33 хувь учраас аж үйлдвэрийн бүтцийн хувьд хөгжиж байгаа орнуудаас хөгжингүй орнуудтай илүү төстэй.Гэвч хөдөө аж ахуйн эзлэх хувь бага мөртөө харьцуулах үзүүлэлтүүдээр өндөр байдаг.Цаашдаа анхан шатны боловсруулалтын үйлдвэрүүд нэмэгдэж, ажиллах хүчинд хөдөө аж ахуйн эзлэх хувь өнөөгийн 40 хувиас нэмэгдэх төлөвтэй байна.Ерөнхийдөө ажиллах хүчин хөдөө аж ахуйгаас аж үйлдвэр рүү шилжих хандлага давамгайлж байна.Гэтэл хотжилтын төвшин одоо 60 хувьтай байгаа учраас цаашдаа хөдөө хүн байхгүй болно гэж эмээх хэрэггүй. Хотод сууршиж буй хүмүүс аж үйлдвэр, тухайлбал хүнсний үйлдвэрлэлийг дэмжвэл энэ хандлагад муу юм байхгүй.

ЗҮҮН АЗИЙН БОЛОН МОНГОЛЫН ШИЛЖИЛТ, ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ЗАГВАРЫГ ҮНЭЛЭН ДҮГНЭХ НЬ

Бид энэ өгүүлэлд эдийн засгийн шилжилт (буюу хөгжил дэвшилт)-д холбогдох хэд хэдэн асуудлыг авч үзлээ. Хөгжил дэвшлийн тухайд бол чухал хэдэн асуудал, түүний дотор төрийн үүрэг, капитал хуримтлуулах олон хувилбартай стратеги (иргэдийн хадгаламж, гадаадаас авах зээл, гадаадын шууд хөрөнгө оруулалт), мөн экспортын үүргийн тухай асуудал юм. Шилжилт, хөгжил дэвшлийн энэхүү хоёр багц асуудал харилцан уялдаа холбоотой. Ийнхүү бид Зүүн Азийн эдийн засгийн хөгжилд чухалчлагдаж байгаа шилжилт, хөгжил дэвшлийн холбогдолтой асуудлуудыг иж бүрдэл байдлаар дор авч үзэх болно.

1. Цочир эмчилгээ, аажим шинэчлэлтийн арга, эмх цэгцтэй, эмх цэгцгүй шилжилтийн тухайд

Цочир эмчилгээний арга болон аажим шинэчлэлт хоорондоо ялгаатай байдагийн тухайд Хятад улсыг аажим шинэчлэлтийн түгээмэл жишээ хэмээн их төлөв үздэг бол Зүүн Европын орнууд, ялангуяа Польш, Орост цочир эмчилгээний аргыг хэрэглэсэн гэж тооцдог. Хятад улс аажим шинэчлэлтийг хэрэгжүүлэхдээ хувьчлалыг хавтгайруулаагүй, улсын үйлдвэрийн газруудыг төсвийн эрс хатуу хязгаарлалтад оруулаагүй онцлогтой. Хятадтай харьцуулахад Вьетнам улсын үйлдвэрийн газруудад гэнэт төсвийн хатуу хязгаарлалт хийж, татаас өгөхөө зогсоосон нь улсын үйлдвэрүүд олноороо хаагдахад хүргэсэн. Энэ утгаар нь Вьетнамыг цочир эмчилгээний арга хэрэглэсэн улсын тоонд бас оруулж байгаа ч Польш, Оросоос ялгаатай нь Вьетнамд бүтээгдэхүүний хэмжээ удтал их хэмжээгээр буураагүй. Ийнхүү ялгаатай байгаагийн уг үндэс нь юунд байна вэ.

Ялгаа нь шилжилтийн үйл явц "эмх цэгцтэй", "эмх цэгцгүй" гэдэгт байна гэж бид үзэж байна. Хятад, Вьетнам хоёрт төр нь шилжилтийн үйл явцад зохицуулагчийн хувиар оролцсон юм. Шилжилтийн үйл явцад хамгийн чухал асуудлын нэг нь хууль бусаар ашиг хайгч (чухамдаа хонжоо хайгч) хувь хүмүүс нийтийн өмчийг дур мэдэн гартаа авч байгаа явдал мөн. Тэрчилэн улсын үйлдвэрийн газрын эрчимтэй хувьчлал нь дотоодын хяналтын систем, хяналт шалгалтын ямар ч механизмгүй явагдаж байгаагаас хараа хяналтгүй менежментийн ажиллагаа болж байна. Өөрөөр хэлбэл төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед улсаас тавьж байсан хараа хяналт алдагдаж, АНУ-ын хөрөнгийн зах зээлийнх шиг юмуу Японд бол төв банкнаас нь тавьж байдаг шиг хяналтын үр нөлөөтэй хатуу механизм үгүйлэгдэж байна. Иймд эмх цэгцтэй шилжилтэд байгууштай нэг сайн зүйл нь бүрэн хэмжээний зах зээлийн

механизм, бусад зохистой бүтэц бий болох хүртэл улсын байгууллага хөндлөнгөөс ажиглан хянагчийн үүрэг гүйцэтгэж; байх явдал юм.Хятадад улсын үйлдвэрийн газраас хувьд шилжсэн хувьцаат корпорацийн хувьцааг олон нийтэд худалдаж, улсын анхдагч хувьцааг эзэмшигч улсын байгууллагыг төлөөлсөн менежерүүд болон шинээр гаргасан хувьцааг авч буй гадны хүмүүсийн хооронд балансын тооцоо хийсэн байна.Вьетнамд бол тухайн үед байгаа улсын үйлдвэрийн газарт гадаадын олон пүүс компани хувьцаа эзэмшигч буюу түншээр оролцож, улсын байгууллагын менежерүүд, гадаадын түншүүд хоорондоо балансын тооцоо хийжээ.

Монголын тухайд, шилжилтийн үйл явц төгс төгөлдөр биш ч гэсэн эмх цэгцтэй байснаараа илүү сайн хэрэгжсэн бөгөөд үүний гол үр дүн нь хувьчлалын дараа дотоодын хяналт тавих чиг хандлага төлөвшиж байгаа явдал мөн гэсэн миний дүгнэлт нотлогдож байна. Монгол улсын хувьд төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц хуучин зөвлөлтийн эвсэл задран унахаас аль эрт тухайн үеийн эрх баригч коммунист намын (МАХН) санаачлагаар эхэлжээ.Өөрөөр хэлбэл, сайтар төлөвлөсөн хувьчлалын хөтөлбөрийг ахар богино хугацаанд хэрэгжүүлж чадсан юм.

Хөдөө аж ахуйн нэгдэл, улсын том жижиг үйлдвэрүүдийг хувьчлахад нэг ёсны дотоодын хяналтад их бага ямар нэг хэмжээгээр саад бэрхшээл учирсан байна.Гэвч дээр дурдсан гурваас хамгийн чухал нь болох улсын томоохон үйлдвэрүүд дэх дотоодын хяналт зүүн Европын орнуудынхтай харьцуулахад туйлын хангалтгүй байжээ. Энэ нь хувьчлагдсан үйлдвэрийн 41 хувь нь улсынх байхаар маш уян хатан тодорхойлон тогтоосон бөгөөд улс ашгийнх нь 15-80 хүртэл хувийг авчээ.Монголын пүүс компаниудад гадныханд ногдож буй хувьцаа өндөр буюу 44,9 хувь байхад дотоодынхонд (менежментээр хувьчилж авсан болон ажилчдад давуу эрхээр ногдсон) хувьцаа 35 орчим хувь байгаа юм.Хувьцааны ийм хуваарилалт Зүүн Европынхтой харьцуулахад илүү сайн байна.Тэнд, тухайлбал Орост дотооддоо ногдох хувьцааны хэмжээ 60 хувь байна. Гэхдээ Монголын дээрхи үзүүлэлт нь Хятадынхтай харьцуулахад тийм ч сайн биш байна.1994 оны байдлаар Хятадад гадаадынханд ногдох хувьцаа нэлээд өндөр буюу 64,6 хувь байхад дотоодынханд 1-ээс хэтрэхтэй үгүйтэй хувь нь ногдож байв.Хятад, Монголын энэ ялгаа нь хувьчлалын аргатай тохирохгүй байна. Чухамдаа бол дөнгөж шинээр гаргасан хувьцааг олон нийтэд нэг мөсөн худалдах арга болон бүхэлд нь хувьчлалын тасалбараар борлуулах арга хоёрын хооронд ялгаа зөрөө гарч байна.Сүүлчийнх нь арга зөвхөн ажилчдад давуу эрх олгож байхад эхнийх нь ерөөс нийт хүн амыг илүү давуу эрхтэй болгож байгаа юм.

Монголд ч, Зүүн Европод ч дотооддоо ногдох хувьцааны хэмжээ хувьчлалыг түргэн хурдацтай явуулахад дөхөмтэйг нь бодолцон дотоодынхонд олгож буй давуу эрхтэй хувь тэнцүү байна.Гэвч тодорхой

хэмжээгээр энэ нь улс төрийн маргаан будлиан, мөн өмч хувьчлалыг эсэргүүцсэн зохион байгуулалттай үйлдлээс болоод хувьчлалын программ хойшлогдох, тэр ч байтугай саатаж зогсвол төлөх төлбөр юм.

2.Шинэ үйлдвэрийн газар болон Улсын үйлдвэрийн газрыг шинэчлэх нь

Шинээр өсч дэвжих эх үүсвэр, эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх хүчин зүйл болохын хувьд улсын үйлдвэрийн газрын хувьчлалыг шинээр гарч ирж буй үйлдвэрүүдтэй харьцуулан авч үзье. Зүүн Европ болон Азийн олон орны шинэчлэлтийн туршлагаас харахад шинэ тутам үүсч байгуулагдсан үйлдвэр, аж ахуйнууд шинэ эрч хүчээр өсч дэвжиж байхад хуучин эдийн засгийн үеийн үйлдвэрүүдэд шилжилтийн үйл явц ерөөс маш удаашралтай байна.Хятад, Вьетнамын туршлага ч бас энэ дүгнэлтэд тохирч байна.Хятадад шинээр гарч ирсэн хөдөөгийн ч, нөгөө талаар гадаадын хөрөнгө оруулалттай хот суурин газрын ч үйлдвэрүүд байхад Вьетнамд гадаадын пүүсүүдтэй хамтарсан улсын үйлдвэрийн газрууд, бас хувийн жижиг үйлдвэрүүд байна.Ийм шинэ тутам үүсч байгуулагдсан үйлдвэр аж ахуйн газрууд түргэн **хурдацтай** өсч дэвжин, тэгснээрээ үнэмлэхүй болон харьцангуй утгаараа зах зээлийн эдийн засгийн өсөлт хөгжилтэд тус дөхөм үзүүлж байгаа юм.Улмаар энэ нь бас зах зээлийн өрсөлдөөнт байдал, сахилгыг төлөвшүүлж байна.

Хувийн шинэ үйлдвэр аж ахуйн газарт дэмжлэг үзүүлж, бололцоо олгох нь зах зээлийн эдийн засгийг төлөвшүүлж, шинэ сэргэг өсөлтийг хангах амар хялбар, дөхөмтэй арга зам мөн гэсэн энэхүү дүгнэлтэд Монголын туршлага ч бас хамрагдаж байна.Хятад улс хуучирсан улсын үйлдвэрийн газруудад урамшууллын, бие даасан элдэв аргаар шинэчлэлт хийх гэж оролдоод бүтэлтэй болоогүй.Тэгвэл Монгол улс ийм оролдлого ерөөс хийгээгүй, харин дэлхийд хамгийн эрс шийдэмгий, эрчимтэй хувьчлалын программын нэг гэж тооцогдохоор тийм программыг хөдөө аж ахуй, жижиг пүүс компани болон улсын томхон үйлдвэрийн газруудад хэрэгжүүлсэн. Энэ утгаараа Монгол улс хөрш зэргэлдээ Хятад, Вьетнамаас илт давуутай юм.

Гэвч энд нэг талаас Хятад улс, нөгөө талаас Вьетнам, Тайвань, Солонгос, Монгол Улсын хооронд чухал чухал ялгаа байна.Энд зах зээлийн сахилгыг төлөвшүүлэх хоёр арга зам байж болох юм. Үүний нэгдэх нь дотоодын пүүс компаниудыг дэлхийн экспортын зах зээл дээр өрсөлдөж чадахуйц болгох, **хоёрт** , гадаадын шууд хөрөнгө оруулалтыг өргөжүүлж, дотоодын шинэ үйлдвэрүүдтэй өрсөлдөх бололцоог, түүнд олгох явдал мөн⁵.Солонгос, Тайвань, Вьетнам улс нэгдэх аргыг, харин Хятад улс хоёрдахь аргыг хэрэглэж байгаа юм.Дотоодын нийт бүтээгдэхүүнийх нь хэмжээтэй харьцуулахад экспорт хавьгүй өндөр байгаагаас нь үзвэл Монгол улс эхний аргыг бас хэрэглэж байгаа бололтой. Энэ бол зөвхөн үндэснийхээ хэмжээнд эдийн засгийн

дорвитой том өөрчлөлт хийх боломж бага, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг өөртөө татах бололцоо муутай бага шиг эдийн засагтай улсын хувьд зүй ёсны ухаалаг сонголт мөн. Гэвч дээрхи улсуудын аль аль нь дотоодын пүүсүүддээ импортын хязгаарлалтын хэлбэрээр зарим нэг дэмжлэг үзүүлж байна. Энэ нь тэдгээр пүүс компанид зарим талаар хөнгөлөлт болж байгаа юм. Энэ хөнгөлөлт нь нэг талаар шинэ тутам байгуулагдсан үйлдвэр аж ахуйн газруудад урамшуулал, нөгөө талаар засгийн газрын анхаарал халамжийн дохио болж байна. Өөрөөр хэлбэл засгийн газраас үзүүлж байгаа энэ хөнгөлөлт нь зохицуулалтын зорилгоор хэрэглэж буй нэг ёсны бодлогын шинжтэй арга хэрэглүүр юм.

АНХДАГЧ НӨХЦӨЛ ХИЙГЭЭД ЧИГ БОДЛОГОО СОНГОХ НЬ

Эцэст нь анхдагч нөхцөл хийгээд стратегийн холбогдолтой асуудал гарч байна. Шилжилтийн тухайд, жишээлбэл Хятадын амжилт нь хөдөө аж ахуйн салбарт өндөр үнэтэй хувьцаа бөөнөөр гаргасан зэрэг анхдагч нөхцөлтэй холбоотой юу аль эсвэл аажим шилжилтийн илүү сайн стратеги хэрэглэсэнтэй холбоотой юу гэдэг нь маргаантай. Зүүн Азийн "бар" улсууд түргэн хурдацтай хөгжиж байгаа тухайд, тэдний амжилтын үндэс нь анх Латин Америкийн улсуудын хэрэглэж байсан дотооддоо хандсан импортыг орлох стратегийн оронд гадаадад хандсан экспортыг дэмжих стратегийг хэрэглэснийх үү аль эсвэл төр улсын бие даасан байдал, хүчин чадал сайн, хүн ам нь хөрөнгө чинээлэг, ангийн бүтэц нь нилээд адил тэгш байдаг зэрэг анхдагч илүү таатай нөхцөл байсных уу гэдэг талаар маргаан гардаг.

Асуудлыг аль талаас нь авч үзлээ гэсэн миний бие энд анхдагч нөхцөлийг арай илүү нөлөөлсөн хэмээн үздэг. Аажим шилжилтийг цочир эмчилгээний аргатай, эмх цэгцтэй шилжилтийг эмх цэгцгүй шилжилттэй эсрэгцүүлэн үзэх нь зөв харьцуулалт биш гэдгийг би дээр нэгэнт өгүүлсэн билээ. Энд аль ч тохиолдолд төрийн үүрэг чухал байдаг. Гэвч төрийн үүрэг анхдагч нөхцөлд тодорхой хэмжээгээр өөр өөр байсан. Түүнээс гадна хөдөө аж ахуйн салбарын хувьцаа асар их байсан нь наанадаж анхдагч өсөлт хөгжлийн нөхцөл болохын хувьд асар их давуу тал мөн гэдэгтэй би санал нэг байдаг. Зүүн Азийн хөгжил дэвшилд ч жишээлбэл экспортын чиг баримжаатай стратегийг хэрхэн сонгож авч, амжилттай хэрэгжүүлж чадсаныг стратегийн баримжаатай үзэл бодлоор тайлбарлах аргагүй. Анхдагч нөхцлүүдээс төрийн хүч чадал, бие даасан байдал хамгийн чухал нь. Зүүн Азийн улсууд бол Күнзийн хатуу чанд дэг жаягтай улсууд бөгөөд хүн ард нь гадаад, дотоодын намчирхсан явцуу ашиг сонирхлоос ангид, бие даасан хүндтэй хүмүүс байдаг.

Анхдагч нөхцөлийн тухай асуудал улс төрийн бодлогын сонголтоос илүү байдаг гэсэн миний байр суурийг Монгол улсын шилжилтийн үеийн туршлага харуулж байна. Корсун, Марелл, нарын үзүүлсэнчлэн хувьчлалын тийм шийдэмгий зоримог программ хэрэгжих болсны хамгийн чухал нэг нөхцөл нь шинэчлэлтийнн эхний үе шатанд дээрхи программыг зохион байгуулалтайгаар эсэргүүцэж чадах хүч

бүрдэж амжаагүй байсан явдал юм. Учир нь тэр үед улс оронд өөрчлөлтийн уур амьсгал орж, ардчилсан хувьсгалын дараа МАХН-ын хуучинсаг жигүүрийнхэн үймж сандарсан байдалтай байсан юм. Бас нэг нөхцөл нь гэвэл, 1990 оноос хойш эрс шинэчлэлтийн талынхан болон шинэ удирдлагын хоорондох хувийн харьцаа тааж мэдэхийн аргагүй байсан бөгөөд шинэчлэлтийн талынхан хувьчлалын программыг бэлтгэхдээ санаанд оромгүй зохион байгуулах чадвартайгаа харуулсан юм.

5. Хожуу үйлдвэржих, зах зээлд хожуу шилжих үйл явцын нийтлэг тал

Дээр бид 1980 болон 1990-ээд оны Хятад, Монгол, Вьетнам дахь “зах зээлд хожуу шилжих үйл явц”, 1960 болон 1970-аад оны Солонгос, Тайвань, Япон дахь “хожуу үйлдвэржих үйл явцтай” холбогдсон хэд хэдэн асуудлыг цогцолбор байдлаар авч үзсэн. Зүүн Ази болон Зүүн Европын шилжилтийн хамгийн зохистой харьцуулалт нь цочир эмчилгээний арга, аажим шилжилтийн хооронд биш харин эмх цэгцтэй, эмх цэгцгүй шилжилтийн хооронд байгаа юм. Хоёрдох маягийн шилжилтэд төрийн үүрэг онцгой чухал бөгөөд энэ нь дотоодын онцгой хяналтын систем хэрхэн тогтоож, тэрчилэн зохицуулалтын зардал төсвийг хэрхэн хэмнэж байгаагаар илэрнэ. Төрийн бие даасан, хүчирхэг байдал нь анхдагч нөхцөлийн нэг хэсэг болохоор анхдагч нөхцөл гэдэг бол шинэчлэлт, хөгжлийн стратегийг сонгохоос илүү чухал юм. Шинэ тутам байгуулагдсан үйлдвэр аж ахуйн газарт бололцоо олгож, хөхүүлэн дэмжих нь хуучин улсын үйлдвэрийн газарт шинэчлэлт хийх гэж зовж зүдрэхээс илүү зах зээлд хожуу шилжих хамгийн хялбар дөхөм хурдацтай арга зам мөн. Хятад улс анхандаа хөдөө нутгийн үйлдвэрүүддээ, Монгол улс хувьчлагдсан бүх үйлдвэртээ харин Вьетнам улс гадаадын хөрөнгө оруулалт бүхий үйлдвэрүүддээ илүү түшиглэсэн байна. Зах зээлийн сахилгыг бэхжүүлэхийн тухайд бол Солонгос, Тайвань, Монгол, Вьетнам улс дэлхийн экспортын зах зээлээс суралцаж байхад Хятадын пүүсүүд дотоодын зах зээл, тэрчилэн гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийг хувьчлалд идэвхтэй оруулах замаар асуудлыг шийдэж байна.

Пүүс компани, үндэсний эдийн засгийн нэгжүүд байлаа ч гэсэн эдийн засгийн ихэнх байгууллагад эрх ашиг, уялдуулан зохицуулалт нь тухайн байгууллага оршин тогтнож, өөдөлж дэвжихэд онцгой чухал ач холбогдолтой байдаг.

Олон талаараа Хятад, Монгол, Вьетнам дахь зах зээлд хожуу шилжих үйл явц нь одоо Солонгос, Тайванийн хожуу аж үйлдвэржих үйл явцтай улам бүр адил төстэй болж байна. Нэг ялгаа нь гэвэл зах зээлд хожуу шилжиж буй дээрхи улсуудад түрээсийг хуучин буюу улсын мэдлийн үйлдвэр аж ахуйн газруудад илүү өгч байхад хожуу аж үйлдвэржсэн Өмнөд Солонгос мэтийн улсад бол хувийн үйлдвэрүүдэд өгч байна. Энэ ялгааны мөн чанар нь хоёр талтай юм. Эдийн засгийн

хуучин байгууллагуудад түрээс өгч байгаа нь сайн хэрэг биш, харин шинээр байгуулагдсан эдийн засгийн нэгжүүд түрээс авалгүйгээр өсч дэвшихдээ улам урт удаан хугацаанд оршин тогтнох чадвартай болж болох юм. Тийнхүү эдийн засгийн шинэ нэгжүүд мөдхөн үндэсний эдийн засагт зонхилох учраас энэ бол маш чухал зүйл. Ер нь 60-аад онд Хятад, Монгол, Вьетнамд түрээсийн хэмжээ Солонгосынхоос бага байсан гэгцгээдэг.

Эргэн санавал 1997 оны сүүлчээс хойш Солонгосыг түгшээж буй эдийн засгийн одоогийн хямралын олон шалтгааны нэг нь зогсоох цаг нь болчихоод байхад чаebolуудад хэт удаан хугацааны турш түрээс өгч байсан юм. Өсөлтийн хурдац өндөр байх үед экспортын бүтээгдэхүүн нь түрээс /гадагш валютын солилцоо, банкны зээлийн татаас/ олгох цорын ганц, тодорхой шалгуур байв. Гэвч экспорт болон зээлийн хоорондох уялдаа холбоо аажмаар алга болсон, боловч зээл олгох өөр зохистой механизмууд бүрдсэнгүй гагцхүү чөлөөт банкны тогтолцоо болон хөрөнгийн зах зээлд л байр сууриа тавьж өгсөн юм. Энэхүү нөхцөл байдал нь цэвэр эдийн засгийн аргаар /экспортын/ бус харин лобби мэтийн улс төрийн аргаар түрээс хөөцөлддөг болоход хүргэж байна. Засгийн газрын хүнд сурталт түшмэдүүд шударга тодорхой үзүүлэлтийг эрхэмлэхийн оронд хууль бус аргаар зээл, хөрөнгийн зах зээлд халдсан хэвээр байна.

6 .Монголын хөгжлийн стратегид зориулсан зөвлөмжүүд: шилжилтийн замаар хөгжиж байгаа жижиг орны загвар

Газар зүйн байрлалыг эс тооцвол хувь хүмүүсийн сонирхол, зах зээлд хожуу шилжих үйл явцад эдийн засгийн хөгжлийн нийтлэг үндэс болсон бололтой. Эдийн засгийн хөгжлийн энэхүү түгээмэл үйл явцад Хятад, Япон зэрэг томоохон улс болон Солонгос, Тайвань, Монгол, Вьетнам зэрэг жижиг улс орнуудын хооронд маш нарийн ялгаа байх шиг байна. Жишиж хэлбэл, том орны хөгжлийн загварт экспортын чиг баримжаа бага, хотжилт удаан байх, дотоодын хадгаламждаа их төлөв түшиглэж, төлбөрийн балансыг илүү чухалчилах зэрэг онцлог талууд байна. Хятадын нүсэр том эдийн засгийн шилжилт, хөгжил дэвшлийн одоогийн болон ирээдүйн зам Япон мэтийн томхон улсын загварыг дагаж байхад харин Монгол, Вьетнам зэрэг жижиг улсын шилжилтийн арга зам нь экспортын чиг баримжааг эрхэмлэдэг, гадаадын хадгаламжид илүү найдаж, төлбөрийн балансыг нэг их чухалчилдаггүй Солонгос мэтийн жижиг орны загвартай илүү төсөө бүхий онцлогуудтай байна.

Бид Монгол улсыг "шилжилтийн замаар хөгжиж байгаа жижиг улс" гэж тодорхойлохдоо, хөгжлийн стратегийнх нь чиглэл болгож дараах зүйлүүдийг зөвлөмж болгомоор байна. Нэгд, жижиг орны хувьд Монгол улс Солонгос, Тайванийн нэгэн адил гадагш чиглэсэн экспортын баримжаатай өсөлтийн хэв загварыг авч хэрэглэвэл зохистой. Энэ утгаар нэг чухал зүйл гэвэл олон улсын хэмжээнд өрсөлдөж чадахуйц

экспортын үйлдвэрлэл бий болгох явдал юм. Хүн ам цөөнтэй болохоор Монгол улсын хувьд хүн хүчний олноор бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх уламжлалт бололцоо хязгаарлагдмал байж болох юм. Үүний оронд хүнсний болон эрдэс баялагийн боловсруулалт гэх мэт анхан шатны боловсруулалтад үндэслэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь илүү тохиромжтой.

Хоёрт, аж үйлдвэрийн бүтэц, ажил эрхлэлтийн тухайд бол цаашдаа хөдөө аж ахуйгаас аж үйлдвэрийн салбарт ажиллах хүч шилжих хандлага зонхилж магадгүй. Шинэчлэлт хийгдсэнээр цомхон хүчээр илүү их бүтээмжтэй ажиллах бололцоо бүрдэн, анхан шатны боловсруулалтын салбар одоогийнхоосоо илүү ихийг үйлдвэрлэж чаддаг болох ёстой. Гэвч энэ нь хотжилтыг заавал эрчимжүүл гэсэн үг биш. Одоо Монголд хотжилтын түвшин өндөр буюу 60 хувьтай байна. Суларсан ажиллах хүчийг хот, хөдөөгийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт шилжүүлбэл зохино. Гуравдагч салбарын эзлэх хувь тэртэй тэргүй өндөр байгаа ч гэсэн хуучин үйлчилгээг шинээр гарч ирсэн орчин үеийн үйлчилгээний салбар болгон бүтцийн өөрчлөлт хийх бололцоотой байх ёстой.

Гуравт, Монгол улс хөгжлийнхээ тусын тулд гадаадын хадгаламжид найдлага тавьж чадахгүй ч гэсэн төлбөрийн балансаа зохицуулж болохуйц зохистой хэмжээнд байлгах нь чухал. Аз болоход хадгаламжийн одоогийн цоорхой тийм ч том биш байгаа бөгөөд харин цаашдаа өсөлт түргэсэхийн хирээр хадгаламжийн цоорхой ихсэж, бас гадаад өрийн түвшин хяналт тавьж болохуйц болох ёстой.

Дөрөвт, эдийн засаг хожуу ч гэсэн зах зээлд шилжиж, зах зээлийн үүрэг өсөн нэмэгдэхэд төрийн үүрэг ч онцгой чухал болно.